


Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын
2025 оны 08 сарын 12 -ны өдрийн
А/178 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ОРОН ТООНЫ БУС БОДЛОГЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:

З.Ган-Очир

Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн
Удирдах зөвлөлийн гишүүн.

Дэд дарга:

Д.Мягмарсүрэн

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын зөвлөх.

Зөвлөлийн гишүүд:

Д.Зоригт

Ерөнхий сайдын дэргэдэх Эдийн засгийн хөгжлийн
төвийн захирал;

С.Отгонбат

Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын
гишүүн;

Г.Батцэнгэл

Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн
Удирдах зөвлөлийн дарга;

Р.Батгэрэл

Монголын үйлдвэрлэл технологийн паркуудын
нэгдсэн холбооны ерөнхийлөгч;

М.Буянбадрах

Монголын хүнд үйлдвэрийн эрдэс холбооны
ерөнхийлөгч;

Н.Мөнх-Идэр

Монголын хүнд үйлдвэрийн эрдэс холбооны
удирдах зөвлөлийн гишүүн;

Т.Мөнхбат

Монголын Геологийн холбоодын нэгдсэн зөвлөлийн
дарга;

С.Мандахбат

Монгол дахь Австралийн худалдааны танхимын
Удирдах зөвлөлийн гишүүн;

М.Давга

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн багш,
судлаач;

Ч.Энхзаяа

Монгол-Германы хамтарсан ашигт малтмал,
технологийн их сургуулийн профессор;

Г.Батцэнгэл

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Судалгаа шинжилгээний
хүрээлэнгийн тэргүүлэх мэргэжилтэн;

Б. Бямбадагва

Монгол нүүрс ассоциацийн Ерөнхийлөгч;

Б.Алтаншагай

Монгол нүүрс ассоциацийн гишүүн;

Ч.Жамсран

Газрын тос, байгалийн хийн хайгуул, олборлогчдын
холбооны гүйцэтгэх захирал;

Ж.Мөнхнаран

Монголын газрын тосны бүтээгдэхүүн
импортлогчдын мэргэжлийн холбооны тэргүүн;

Н.Дорждарь

Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгийн
Монгол дахь менежер;


Ш.Цолмон	Олборлох салбарын ил тод байдлын санаачилгын ажлын албаны зохицуулагч;
С.Цэвэгмэд	Жонш олборлогч, үйлдвэрлэгч, экспортлогчдын холбоо;
О.Батболд	Монголын тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын зөвлөл ТББ-ын удирдах зөвлөлийн даргаб

Зөвлөлийн нарийн бичгийн дарга:

Б.Лхамсүрэн	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын ахлах мэргэжилтэн;
Ц.Батгэрэл	Коммуникаци, олон нийтийн харилцааны зөвлөх.

~oOo~

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын
2025 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн
4/12 дугаар тушаалын хоёрдугаар дугаар хавсралт



ОРОН ТООНЫ БУС БОДЛОГЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Монгол Улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын дэргэдэх Орон тооны бус бодлогын зөвлөлийн /цаашид Зөвлөл гэх/ үйл ажиллагаанд энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Зөвлөлийн үндсэн зорилго нь хариуцлагатай ил тод, эрдэс баялгийн хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, олон нийтийн эрдэс баялгийн талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх, төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд зөвлөмж гаргах, дэмжлэг үзүүлэх зорилготой.

1.2.1. Салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хөрөнгө оруулалтын орчныг олон улсад өрсөлдөхүйц хэмжээнд хүргэх талаар зөвлөмж гаргах;

1.2.2. Хариуцлагатай, ил тод уурхайг хөгжүүлэх, сурталчлах, салбарын мэдээллийг олон нийтэд хэрхэн зөвөөр хүргэх талаар төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;

1.2.3. Аж үйлдвэр эрдэс баялгийн салбарыг бусад улс орны уул уурхайн салбартай харьцуулж, өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, зөвлөмж гаргах;

1.2.4. Эрдэс баялгийн салбарт тулгамдаж буй урт хугацааны болон цаг үеийн асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар бодлогын зөвлөмж гаргах;

1.3. Зөвлөл нь Монгол Улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын дэргэд орон тооны бус, байнгын ажиллагаатайгаар үйл ажиллагаа явуулна.

1.4. Зөвлөлийн үйл ажиллагаа нь улс төрөөс ангид, урт хугацаанд тогтвортой явагдах ба Зөвлөл үйл ажиллагаандаа хууль дээдлэх ёс, хараат бус байдал, харилцан бие биеэ хүндэтгэх, ил тод нээлттэй байх, талуудын оролцоог хангасан, үр дүнд чиглэсэн байх зэрэг зарчмуудыг баримтална.

1.5. Зөвлөлийн ажиллах журам, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын тушаалаар батална.

ХОЁР. ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

2.1. Зөвлөлийн ажиллах зарчим нь хурал байх бөгөөд дараах бүтэцтэй байна.

2.1.1. Зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүд, нарийн бичиг;

2.2.Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд батална.

2.3.Зөвлөлийн хурал нь ээлжит ба ээлжит бус хэлбэртэй байх бөгөөд ээлжит хурлыг улирал тутамд, ээлжит бус хурлыг шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Зөвлөлийн дарга Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдтай зөвшилцөн тухай бүрд зарлан хуралдуулна.

2.4.Зөвлөлийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт болон товыг Зөвлөлийн ажлын төлөвлөгөөний дагуу буюу Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Зөвлөлийн дарга батална.

2.5.Зөвлөлийн ээлжит бус хурлаар тухайн хурлыг зарлан хуралдуулах болсон үндэслэл болон хурлын товыг ажлын 3-аас доошгүй өдрийн өмнө зарлана.

2.6.Зөвлөлийн нарийн бичиг Зөвлөлийн даргатай зөвшилцөн хурлын бэлтгэлийг хангах, хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төслийг боловсруулна.

2.7.Зөвлөлийн нарийн бичиг хуралдааны тэмдэглэлийг Зөвлөлийн гишүүдэд хурал болсноос хойш ажлын 7 өдрийн дотор хүргүүлэх бөгөөд Зөвлөлийн гишүүд ажлын 3 өдөрт багтаан нэмэлт тодруулга авч, саналаа ирүүлж болно.

2.8.Зөвлөлийн нарийн бичиг ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлж, зохион байгуулалтаар хангана.

ГУРАВ. ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ, ХУРЛЫН ДЭГ

3.1.Зөвлөлийн хурлыг нийт гишүүдийн олонх ирсэн тохиолдолд хуралдуулах бөгөөд хурлыг Зөвлөлийн дарга, түүний түр эзгүйд дэд дарга даргална.

3.2.Зөвлөлийн хурал нь хэлэлцэх асуудлын жагсаалтын дагуу явагдах ба хурлын үргэлжлэх хугацааг хурал даргалагч тогтооно. Заасан цагт асуудлуудыг хэлэлцэж дусаагүй тохиолдолд хуралд оролцогчдын олонхын саналаар хурлын хугацааг сунгана.

3.3.Зөвлөлийн гишүүдийн санал болгосноор тухайлсан асуудлаар ажлын хэсэг байгуулж болох бөгөөд ажлын хэсгийг Зөвлөлийн даргын тушаалаар батална.

3.4.Зөвлөлийн гишүүд болон ажлын хэсгийн ахлагч нар хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Энэ тохиолдолд тухайн асуудлыг хэлэлцэх бэлтгэл хангагдсан эсэхийг харгалзан хуралд оролцогчдын дийлэнх олонхын саналаар хэлэлцэх асуудлыг жагсаалтад оруулна.

3.5.Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг ач холбогдолгүй ерөнхий танилцуулга, мэдээлэл, мэдэгдэл, хэлэлцүүлгээс зайлсхийж, гагцхүү хэлэлцэх асуудалд хамаатай мэдээлэл, хэлэлцүүлгийг ойлгомжтой, хүртээлтэй, практик хэлбэрээр явуулна.

3.6.Зөвлөлийн хурлаар хэлэлцэж байгаа аливаа асуудлыг зөвшилцлийн үндсэн дээр буюу нэгдсэн саналд хүрэх замаар шийдвэрлэнэ. Нэгдсэн саналд хүрээгүй тохиолдолд тухайн асуудлыг хойшлуулах, эсхүл Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдаас чиглэл авах замаар шийдвэрлэж болно.

3.7.Зөвлөлийн хурлын ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор хэлэлцэж буй асуудлаас хамааран Зөвлөлийн дарга, Дэд даргатай зөвшилцсөний үндсэн дээр хэвлэл мэдээллийн хэрэгслийг хуралд оруулах эсэхийг шийдвэрлэнэ.

3.8.Хурлаас гарсан санал, зөвлөмж, шийдвэрийг Зөвлөлийн дарга, Дэд дарга албажуулсан хувилбарыг Зөвлөлийн гишүүдэд хүргүүлнэ.

ДӨРӨВ. ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1.Зөвлөлийн гишүүн Зөвлөлийн жилийн болон хагас жилийн ажлын төлөвлөгөөнд санал оруулах, хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад санал гаргах, нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд энэхүү саналаа албан бичгээр Зөвлөлийн даргад хүргүүлнэ.

4.2.Зөвлөлийн гишүүн тодорхой асуудлаар Ажлын хэсэг байгуулах, түүнийг ахлах, бүрэлдэхүүнд нь ажиллах санал гаргах эрхтэй.

4.3.Зөвлөлийн болон ажлын хэсгийн гишүүд хурлын зарласан цагт хуралд тогтмол оролцох үүрэгтэй.

4.4.Зөвлөлийн гишүүн өөрийн биеэр хуралд ирэх боломжгүй тохиолдолд Зөвлөлийн нарийн бичигт урьдчилан мэдэгдэж, хэлэлцэж буй асуудлын талаарх саналаа бичгээр ирүүлж болно.

4.5.Зөвлөлийн гишүүдээс хуралд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3 ба түүнээс дээш удаа оролцоогүй тохиолдолд Зөвлөлийн дарга тухайн гишүүнийг Зөвлөлийн бүрэлдэхүүнээс гаргах саналыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад бичгээр мэдэгдэнэ.

ТАВ. АЖЛЫН ХЭСЭГ

5.1.Ажлын хэсгийн үүрэг нь Зөвлөлийн хурлаар хэлэлцэхээр хүлээгдэж буй асуудлыг ач холбогдлоор нь эрэмбэлэн тодорхойлох, хэлэлцэх, түүний шийдлийг Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхэд оршино.

5.2.Ажлын хэсгээс дэвшүүлж буй санал, шийдэл нь нотолгоо, шинжилгээнд суурилсан, судалгаанд үндэслэсэн байна.

5.3.Ажлын хэсгийг байгуулах болон бүрэлдэхүүнийг Зөвлөлийн хурлаар батална.

5.4.Ажлын хэсгийн чиг үүргээс хамаарч түүний бүрэлдэхүүнд Зөвлөлийн гишүүдээс гадна сайдад тухайлан зөвлөмж гаргаж болох бөгөөд холбогдох төрийн байгууллага, мэргэжлийн холбоод, гадаад, дотоодын бизнесийн холбоод, танхим, их сургууль, судалгаа шинжилгээний хүрээлэн зэрэг байгууллагуудын тухайлсан асуудлаар мэргэшсэн төлөөллүүдийг зөвшилцсөний үндсэн дээр оруулж болно.

5.5.Хэвлэл мэдээллийн хэрэгслийг ажлын хэсгийн хуралд оролцуулахгүй бөгөөд ажлын хэсгийн ахлагч, эсхүл ажлын алба товч мэдээлэл хийж болно.

ЗУРГАА. САНХҮҮЖИЛТ

6.1.Зөвлөл болон ажлын хэсгийн үйл ажиллагааны зардлыг гишүүд өөрсдийн нөөц бололцоонд үндэслэн шийдвэрлэнэ.

6.2.Зөвлөл болон ажлын хэсгийн үйл ажиллагаанд зориулан хувийн хэвшил, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудаас эргэн төлөх нөхцөлтэй зээлээс бусад хэлбэрээр хандив, тусламж зэргээр санхүүжилт авах боломжтой.

ДОЛОО. БУСАД

7.1.Зөвлөлийн журам нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

~oOo~